АГУУЛГА

1.1 Төслийн хэрэгжүүлэгчийн мэдээлэл 1
1.2 Төслийн зорилго, зорилт 1
1.3 Төслийн ач холбогдол 1
1.4 Төсөл хэрэгжих талбайн байршил 1
..... 2
1.5 Төслийн хүчин чадал 2
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл 3
2.2 Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга 3
2.2 Төсөл хэрэгжих газрын ургамлан бүрхэвч 4
3.1 Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөлөл 5
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг Магадлан жагсаах аргаар үнэлэх 5
4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт 8
4.2 Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө 9
4.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 12
4.4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 13
4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 14
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 15
4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 16
4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө 17

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Солар энержи чандмань” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011657099
Регистрийн дугаар	6156819
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп, 32/1 2 тоот
Утас	99116914

1.2 Төслийн зорилго, зорилт

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрт сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах замаар эрчим хүчний түлхүү ашиглах замаар эрчим хүчний төвлөрсөн системийн найдвартай ажиллагааг хангах, улсын нийт эрчим хүчний 20-25 хувийг сэргээгдэх эрчим хүчээр үйлдвэрлэх, системийн алдагдлыг одоогийн түвшингээс 10-аас доошгүй хувиар бууруулахаар заасан нь төслийн гол зорилго болно.

Орон нутгийн хэмжээнд авч үзвэл тус төлийг хэрэгжүүлснээр дараах эерэг нөлөөтэй зорилтуудыг биелүүлнэ.

- Аймаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Төслийн барилгын явцад 40 гаруй хүн ажлын байраар хангагдаж ажиллана. Төслийн ашиглалтын хугацааны туршид станцын ашиглалт үйлчилгээг явуулах 32 тогтмол ажлын байр бий болно.
- Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд хувь нэмэр болно
- Эрчим хүчний хангамжийн найдвартай байдал дээшилнэ.
- Цахилгаан станц нь шавхагдашгүй сэргээгдэх нөөцтэй нарны гэрлийг түлшээ болгон ашиглах тул байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол үүсгэхгүй эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болно.
- Цаашилбал нийт ард иргэдийн ногоон эрчим хүчний талаарх ойлголт, боловсролыг дээшлүүлнэ.

1.3 Төслийн ач холбогдол

Сүмбэр суманд 21МВ-тын нарны цахилгаан станцыг барих нь Улаанбаатар болон бусад хот суурин газарт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбон ашиглах, говийн бүсэд их чадлын нарны станц байгуулж төвлөрсөн эрчим хүчний системд холбох тухай “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн заалтуудыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

1.4 Төсөл хэрэгжих талбайн байршил

“Солар энержи чандмань” ХХК нь Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт Засаг даргын 2017 оны 08 сарын 23 өдрийн А/204 тоот шийдвэрээр 4116036168 нэгж талбарын дугаар бүхий 49.953 га газрыг 15 жилийн хугацаатай 000011418 газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан.

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжих талбайн газарзүйн солбилцол

	Тэгш өнцөг		
	X	Y	Урт
1	594323.16	5344695.27	1317.09
2	593320.34	5345548.54	509.94
3	593656.40	5345931.88	339.49
4	593919.55	5345717.55	239.50
5	593893.92	5345479.50	838.85
6	594532.65	5344936.10	319.29



Зураг №. 1 Төсөл хэрэгжих талбайн байршил

1.5 Төслийн хүчин чадал

“Солар Энержи Чандмань” ХХК-ий хэржүүлэх Төв аймгийн Баянчандмань сумын нутагт байрлах 21КВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих төсөлд JA solar нарний зайн үйлдвэрийн JAM6-72-315/SI маркийн 315 Вт-ын чадалтай монокристалл цахиурын нарны зайг ашиглахаар тооцсон. БНХАУ-ын JA solar компани нь 2015 оны нарны зай үйлдвэрлэлээрээ дэлхийд III-рт ордог томоохон компани юм. БНХАУ-ын JA solar нарны зайн техникийн үзүүлэлт , гадаад биет байдлын техник үзүүлэлтийг хүснэгт болон зургаар үзүүлэв.

БНХАУ-ын Jinko Solar нарны зай нь IEC, EC, TUV, UL болон Европын стандартыг хангасан 25 жил хүртэлх хугацаанд ашигт үйлийн коэффициентийн бууралт 16.14% байх баталгаат үйлдвэрлэгчдийн зүгээс гаргасан байдаг. Орчны температур- 40°C- +85°C хэмд ашиглаж болох ба монгол орны уур амьсгалд тохирох үзүүлэлт юм.

Нарны цахилгаан станц нь модуль модулиар хийж хүчин чадлыг нь хэрэгцээнийхээ дагуу өөрчлөх боломжтой. Баянчандмань 21МВт-ын нарны цахилгаан станц нь тус бүр 875кВт-ын хүчин чадалтай

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Тус сумын нутаг нь элэгдэл идэгдлийн, зөөгдөл хуримтлалын гадаргуу бүхий геоморфологийн гол хэв шинжийг бүрдүүлнэ. Төвийн хэмжээнд зөөгдөл хуримтлалын гадаргуу буюу уулын бэлт-хормойн хэсэг зонхилно.Баянчандмань сум орчмоор илрэх хуримтлалын гадаргуу нь төвийн багахан хэсгийг хамарсан байна.

Баянчандмань хотгорт Дээд болон орчин үеийн дөрөвдөгч, Цэрд, Карбоны настай хөрс, чулуулагт агуулагдсан 3 төрлийн уст давхарга илэрдэг.Эдгээрээс огт төлөвлөлтөнд нөлөөлөх гол уст давхарга нь дээд болон орчин үеийн дөрөвдөгчийн настай уулын бэл хормойн хурдсанд хадгалагддаг хөрсний ус бөгөөд ихэвчлэн олон жилийн цэвдэг тул хөрсний дээр оршдог. Газрын гадаргуугаас 2,0-4,0м-ийн гүнд 0,5-2,0м-ийн зузаантай илэрдэг.

Сумын нутаг дэвсгэр нь тохиолдлын байдалтай тархсан цэвдэгтэй бүсэд хамаарагдана. Нутаг дэвсгэрийн хэмжээнд цэвдэг ул хөрс 2,7-3,7м-ийн гүнээс илэрдэг бөгөөд хөрсний дэд хил, улирлын хөлдөлтийн гүний доод хилтэй нийлдэг.

Уур амьсгал

Төв аймгийн нутаг нь өндөршлийн ялгаа багатай байдаг учраас дулаан хүйтний хэлбэлзэл байгатай юм. Тус аймгийн Туул, Хэрлэн, голын сав дагуух буюу далайн түвшнээс дээш 1250 метрээс дээш өргөгдсөн нутагт жилийн дундаж агаарын температур -1,4 градус хүйтэн байгаа нь өвлийн улиралд бусад нутгаас арай илүү хүйтэн байдагтай холбоотой юм. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1дүгээр сар бөгөөд олон жилийн дунджаар температур -26°С хүйтэн. Үүнээс үзэхэд тус аймгийн уулсын хоорондох тал хөндийд 1дүгээр сард бусад нутгаасаа хйүтэн байдаг бөгөөд Баянчандмань сум орчмоор -40,1-46-,4 градус хүрч хүйтэрсэн байна. Хөрсний гадаргын температурын тухайд 1 дүгээр сард дундаж температур -20°с-ээс, -25°С, 7 дугаар сард дундаж температур 21°С-ээс 26°С байдаг.

Агаар

“Солар Энержи Чандмань” ХХК-ийн “Нарны цахилгаан станц” байгуулах төсөл нь Төв аймгийн Баянчандмань сумын нутагт байрлах бөгөөд аймгийн төвлөрлийн бүсээс зайдуу, хүн амын суурьшилт бага тул агаарын бохирдол бага харьцангуй цэвэр агаартай бүсэд байрлана.

Гадаргын ус

Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны сав газрын ангиллаар Хараа голын сав газарт хамрагдана. Энэхүү сав газар нь 17463,4км2 талбайтай бөгөөд Баян, Сөгнөгөр, Хужирт, Өлгий, Балж, Дарст, Бороо, Загдал, Наран зэрэг томоохон цутгал голуудтай.

2.2 Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга

Төсөл хэрэгжих талбай болох Төв аймгийн Баянчандмань сумын нутаг нь сайр чулуурхаг, хар хүрэн, уулын хар шороон хөрс голлон тархсан байна.

- Хад асга бүхий өндөр уулын нугын хөрс
- Уулын цэвдэгт тайгын хөрс
- Уулын ширэгт тайгын хөрс
- Уулын ойн бараан хөрс
- Уулын хар шороон хөрс

- Уулын хар хүрэн хөрс
- Ам хөндийн хар шороон хөрс
- Нугын хөрс зэрэг үндсэн 8 хэв шинжид хуваагдана.



Зураг №.2 Хөрсөн бүрхэвч

2.2 Төсөл хэрэгжих газрын ургамлан бүрхэвч

Төсөл хэрэгжих болон түүний ойр орчмын нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, дагуур Монголын /Төс Азийн/ дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана.



Зураг №. 3 Ургамлын бүрхэвч

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хамааран хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийг тооцоолон ArcGIS 10.5 программд зураглахад 100 метрийн радиуст нөлөөллийн эрчим их буюу хүчтэй, 200 метр радиуст нөлөөллийн эрчим дунд буюу саармаг, 300 метрийн радиуст нөлөөллийн эрчим бага буюу сул байна.

3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг Магадлан жагсаах аргаар үнэлэх

Ерөнхий арга зүй дээрээ тулгуурлан байгаль орчны нөлөөллийг магадлан жагсаах аргаар тодорхойллоо. Нөлөөллийн үнэлгээг доорхи хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт №. 2 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөлөл		Үр дагаварын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
Агаар	Төслийн бүтээн байгуулалтын ажлын үед барилга байгууламжийн материал тоног төхөөрөмжийг ачиж буулгах, ногоон байгууламжийн бий болгох зэрэг үйл ажиллагаас тодорхой хугацаанд тоосжилт үүсч болзошгүй.			ST		
	Төслийн бүтээн байгуулалтын ажилд ашиглагдаг хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсч болзошгүй.			ST		
	Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг шатааж устгах нөхцөлд хортой хий ялгарч, агаарын бохирдол бий болгож бозошгүй		ST			
	Төслийн бүтээн байгуулалтын ажлын явцад дизель станц ажиллуулах, шатах тослох материалын агуулах, автомашин болон хүнд даацын машин механизмыг шатахуунаар цэнэглэх зэрэг үйл ажиллагааны үед агаар ууршилт үүсч болзошгүй		ST			
Хөрс бүрхэвч	Төслийн бүтээн байгуулалтын /нарны зайн дэлгэцийг суурилуулах, удирдлага, хяналтын байр, дэд станц, авто машины зогсоол/ зэргийг барьж байгуулах явцад хөрс эвдрэх			LT		
	Тоног төхөөрөмж тээвэрлэх, ачиж буулгах үед хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэх			LT		
	Нийт ажиллагсдын ахуйгаас гарч буй хатуу, шингэн хаягдлыг тусгайлан заагдаагүй цэгт хадгалж зайлуулаагүйгээс хөрсөн бүрхэвч үржил шимт шинж чанараа алдаж бохирдох			ST		

	Ашиглалтгүй болсон нарны зайн дэлгэц, батарей зэргийг зориулалтын цэгт зайлуулаагүйн улмаас хөрс химийн элемент буюу цацраг идэвхт бодисоор бохирдож болзошгүй.		LT			
Эрүүл мэнд	Төслийн үйл ажиллагааны бүтээн байгуулалтын үед өндөр давтамжтай, дуу шуугианы бохирдолтой хэсгийн ажилчид хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх			MT		
	Тухайн төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгслүүд болон бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй жижиг техник хэрэгслүүдээс агаарт цацагдах хортой хий хүлцэх хэмжээнээс хэтэрч болзошгүй		ST			
Ургамлан бүрхэвч	Бүтээн байгуулалтын ажлын үед болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлт ажилчдын ирж очих зэрэг байнгын машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт нь ургамлын фотосинтезийн үйл явцад нөлөөлөх			MT		
	Төслийн талбайд автотээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагааны улмаас ургамал ургаж буй газруудыг талхагдалд оруулах			ST		
	Төслийн талбайд зориулалтын зам, талбайг тохижуулж тэмдэгжүүлээгүйн улмаас ургамлан нөмрөг талхагдаж болзошгүй					
Амьтаны аймаг	Төсөлд ашиглах тоног төхөөрөмжийг ачих, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаанаас гарах дуу чимээ нь амьтдыг үргээх, амьдрах орчиныг өөрчлөх		ST			
	Санамсаргүй үйл ажиллагаанаас төсөлд ашиглах тээврийн хэрэгслээс шатах тослох материал алдагдсанаар сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчдэд нөлөөлж болзошгүй.					
Газрын гадарга	Төслийн бүтээн байгуулалтын нөлөөнд төслийн талбай элэгдэл эвдрэлд өртөнө. Бүтээн байгуулалтын ажлын дараа эвдэрсэн газарт нэг наст болон олон наст ургамал тарьж хамгаалан бордох хэрэгтэй.			LT		

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

шууд нөлөөлөл

болзошгүй нөлөөлөл

хам нөлөөлөл

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна. Тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолсон дээрх матрицын аргаас үзэхэд тус нарны цахилгаан станцын байгууламж барихад байгалийн төрх болон хөрс, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлэх нь харагдаж байна.

БҮЛЭГ 4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Солар энержи чандмань” ХХК-ийн “21МВ-тын нарны цахилгаан станцыг хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;

2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болгосон болно.

Тус төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг аялууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны

менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2026 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 5 489 000 төг зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хүснэгт №. 3 БОМТ-ний задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	400,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	200,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,479,000
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	450,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	360,000
9	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	1300,000
10	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	300,000
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		5.489.000

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Солар энержи чандмань” ХХК-ийн “21МВ-тын нарны цахилгаан станцыг хэрэгжүүлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт зэргийг үндэслэн хийсэн болно.

Хүснэгт №. 4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэж зам харгуй олшрох, ахуйн хог хаягдлын сав, бохирын нүхний битүүмжлэл муу байх, шатах тослох материалын ууршилт зэргээр агаар дахь тоосжилт, PM, CO, SO_2, NO ихсэж орчны хүчилтөрөгчийн хэмжээ багасч болно.	Нарны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын албан татварыг төлөх	Автомашины зогсоолын талбай,засварын талбай					+	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ MNS 4943:2014 Усны чанар, хаягдал бохир ус.
		Нарны цахилгаан станцын дэлгэцийн хоорондох явган хүний зам гаргах	Автомашины зогсоолын талбай, дэлгэцийн хоорондох явган зам					+	
	Хөрсөн бүрхэвч								
	Тээврийн хэрэгслүүдийн зогсоолын зам талбайг бетонон	21МВ-тын нарны цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг зураг төсөлд						+	“Газрын тухай” хууль

	хучилттай болгоогүй, машин техник тоног төхөөрөмж, хуучирч элэгдэн эд анги, шатах тослох материал, хөдөлгүүрийн шингэн зэрэг алдагдаж хөрсөнд бохирдол үүсгэх	заасан талбайд хэрэгжүүлэх, төслийн талбайн хил хязгаарыг хашаажуулах							MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн Хог хаягдлын тухай хууль,
		Хог хаягдал, тээврийн хэрэгслийн зогсоол орчмоос жилд 1 удаа хөрсний дээж авч шинжлүүлэх						+	
		Барилгын ажлын явцад болон дууссаны дараа барилгын талбайг цэвэрлэж, хог хаягдлыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд заасны дагуу зайлуулж, устгах арга хэмжээг тогтмол авч байх						+	
	Ургамлан нөмрөг								
	Ургамлан нөмрөг байгалийн төрх бүрэн өөрчлөгдсөн тул энэ нь ургамлан нөмрөгт нөлөөлөх үндсэн нөхцөл болох	Нарны станцын ашиглалтгүй боломжит талбайд ногоон байгууламж бий болгох						+	“Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
Нийт	**400000**								

4.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн бүтээн байгуулалтын эхний жилд тоног төхөөрөмжийн суурилуулалт, ажилчдын барилга байгууламж барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг эхлэхээр төлөвлөсөн. Иймд 2026 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2026		
	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ						
1	Зохион байгуулалтгүй аялал жуулчлал, зүй бус ашиглалтаас Байгалийн үзэсгэлэнт газруудын орчин хог хаягдлаар бохирдож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч, байгалийн унаган төрх алдагдаж байна.	Төслийн талбайд ашиглалтын талбайн 20% буюу 0,04 га талбайд 10 ш мод тарих.	Үйл ажиллагааны эхэнд	10ш * 200 = 200 000	-	200,000	MNS 5914:2015, MNS 4597:2013
	Нийт дүн, мян.төг		**200 000 төг**				

4.4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	**Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар хэмжээ**	**Тоо хэмжээ**	**Нэгжийн зардал**	**Нийт зардал (мян\төг)**	**Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж**	**Баримтлах эрх зүйн баримт бичиг**
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд цахилгаан станцын бүх ажилчдад	-	179,000		2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог тогтмол хийх, байнгын хяналт тавих		-	2,000,000		2026 он	
	Станцын цахилгана тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй боловсон хүчинг мэргэжлийн хүнээр бэлтгэх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох		-				
	Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэх байх осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх		-				
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах		-				
	Байгаль цаг уурын гэнэтийн үзэгдлээс чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх эрсдэлтэй тул цаг агаарын байдалтай уялдуулж ажиллах		Бүх ажилчдад	200,000		2026 он	
				100,000			
Нийт зардал (мян.төг)				**2,479,000**			

4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2026 он	
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах.	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад				150.00	+	Хог хаягдлын тухай хууль
	Хогийн савны хэмжээг хог хаягдлын үүсэх байдалтай уялдуулан хийх нь зүйтэй бөгөөд ажлын байрнаас үүсэх хог хаягдлын бүрдлээс хамаарч оффис болон бусад газруудад тавих хогийн савнуудыг өөр өөр байлгана.	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасанаар	+	
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Төслөөс хог хаягдлыг Төв аймгийн Баянчандмань сумтай хог хаягдлын гэрээ хийнэ.	Ахуйн хаягдлын хүрээнд	-	-	-	-	+	
Нийт		450000 төг						

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2026 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 1 цэг сонгох /Нарны цахилгаан станцын кемп орчим/	Хагас жил тутамд	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойолох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Нарны цахилгаан станцын кемп/	Хагас жил тутамд	Жилд 1 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 20.0 төг/	
Усны хяналт шинжилгээ								

2	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2026 он	Жилд 1 удаа	40.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2026 он				
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН							**360000**	

4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	**Хэрэгжүүлэх арга хэмжээ**	**Арга хэмжээний цар хэмжээ**	**Нэгжийн өртөг мян.төг**	**Зардал мян.төг**	**Хугацаа 2026 он**
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Үйлдвэрийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2026 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрийн осол гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг дотооддоо зохион байгуулах.	Үйлдвэрийн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2026 он
3	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах	Үйлдвэрийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				**1300 000 төг**	

4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	**Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр**	**Мэдээний агуулга**	**Хугацааны тов**	**Тайлагнах зардал, төг**	**Зохион байгуулах албан тушаалтан**	**Зохион байгуулах газар**
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Төв аймгийн байгаль орчны газар цахимаар хүргүүлнэ.	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2026 оны 11-р сар	300,000	БО-ны мэргэжилтэн, үйлдвэрийн дарга	
БОУАӨЯ-ны ХБОБНГ-т цахимаар хүргүүлнэ.	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх				
Нийт		**300 000 төг**				